

ТАЛ ХЭЭРИЙН БҮСИЙН ХИЛ ХАМГААЛАЛТАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

А.Амгаланбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн тэнхимийн ахлах багш, дэд хурандаа

Товч агуулга: Тал хээрийн бүсийн улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдахад эерэг, сөрөг талуудад тохирсон хамгаалалтын бодомж, хувилбар боловсруулах талаар судлахыг зорилоо.

Abstract: It is intended to study the development of security considerations and scenarios suitable for the positive and negative aspects of organizing and managing the state border defense of the steppe region.

Түлхүүр үг: Хил хамгаалалт, тал хээрийн бүс, бүсчилсэн хамгаалалт, бодомж, инженер, техник

Keywords: Border protection, steppe zone, regional protection, thought, engineering, technique

ТАЛ ХЭЭРИЙН БҮСИЙН ХИЛ ХАМГААЛАЛТ

Тал хээрийн бүс нь далайн түвшингээс дээш 550-1200 метр өндөрт өргөгдсөн Дорнод Монголын тал нутаг, Халх, Нөмрөгийн дархан цаазат газрын А бүс, тусгай хэрэгцээний газрууд бүхий Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Онгон, Дарьганга, Наран, Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Халх гол, Матад, Баянтүмэн, Чойбалсан, Чулуунхороот, Дашбалбар, Баяндун, Баян-Уул зэрэг 2 аймгийн 13 сумын 107.6 км² нутаг дэвсгэрт Монгол Улсын хилийн 24.4 хувийг хариуцан хамгаалж байдаг бөгөөд хил хамгаалалтын хүч хэрэгслийн нягтрал, тэдгээрийн бодит боломж, хамгаалж байгаа хэсгийн онцлогоос шалтгаалж харилцан адилгүй байна. Монгол-Хятадын усан хилийн 90 гаруй хувь нь зөвхөн энэ хэсэгт хамаарагддаг.

Байгаль цаг уурын онцлог нь: Тэгш тал, элсэн манхан, уул, толгод, гуу жалга, гол, горхи, нуур, намаг, хусан ойтой, үржил шимт хөрстэй, ургамлын гарц, малын бэлчээр сайн.

Цаг агаараас шалтгаалж зун явахад хүндрэлтэй газар нь өвөл явж болдог, өвөл явахад хүндрэлтэй газар нь зун явж болдог зэрэг онцлогтой нь хил зөрчигч явж болзошгүй чиглэлийг тогтооход хүндрэлтэй.

Хил хамгаалалтын явцад хилийн инженер техникийн төхөөрөмжлөл, өнгөлөн далдлах арга хэмжээнд нэмэлт хүч хэрэгсэл шаарддаг.

Мөн газар орны ил задгай шинж чанар нь хил зөрчигчийн зүгээс хилийн манаа, харуул, хилийн застав, бэлтгэл хүчний байрлал, хүч хэрэгсэл шилжүүлэн байрлуулж, марш үйлдэх

зэргийг тагнаж илрүүлэхэд хялбар болгодог.

Байгаль цаг уурын нилээд өвөрмөц хэд хэдэн онцлог хүчин зүйл нөлөөлдөг. Үүнд:

- Хөрсний байдлаас болж шороо, тоосны нөлөөлөл
- Хөрсний гүнээс авдаг усны өвөрмөц найрлага, өөрөөр хэлбэл хатуу усны нөлөөлөл
- Энэ бүсийн цаг уурын онцлог өөрчлөлт температурын их зөрүү, ялгааны нөлөөлөл
- Нарны хурц гэрлийн бие бүрэлдэхүүн, техникт үзүүлэх нөлөөлөл
- Агаарын чийгшилт харьцангуй бага хуурай агаарын нөлөөлөл
- Тасралтгүй үлээх салхины нөлөөлөл
- Газар оронд баримжаалж болох байгалийн ба хиймэл тэмдэгтүүд ховор учир төөрөх, цаг хугацаа алдах нөлөөлөл
- Өнгөлөн далдлалт хийхэд бэрхшээлтэй зэргүүд байна.

Хилийн отрядоос застав хооронд болон хилийн дагуух зам харгуй бартаа саад багатай.

Хилийн бүс зурваст оршин суугчид, ажил үйлдвэр эрхлэгчдийн нягтрал нэмэгдэх хандлагатай. Уг бүсийн хил орчмын нутаг дэвсгэрт 42600 гаруй хүн ам оршин суудаг.

Хил хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйл: Хил хамгаалалтыг зохион байгуулж явуулахад бие бүрэлдэхүүн, албаны амьтад, зэвсэг, техникт физик-газар зүй, байгаль цаг уурын онцлог хүчин зүйлүүд голлох нөлөө үзүүлдэг бөгөөд тэдгээрийг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай. Байгалийн хүчин зүйлийн үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг урьдчилан тооцох нь улсын хил хамгаалалтын зохион байгуулалт,

боломжийг нэмэгдүүлэх нэг үндэс болно.

Эерэг тал нь:

- Нэг цэгээс хяналтад хамрагдах хэсэг ихтэй, хүч хэрэгслийн шилжилт хөдөлгөөн үйлдэх боломж өндөр;
- Улсын хил хамгаалалтыг суурин болон хөдөлгөөнт харуулаар хамгаалах боломжтой;
- Хилийн инженерийн байгууламжийг хил хамгаалалтад ашиглах тохиромжтой;
- Бүх төрлийн хүч хэрэгсэл, уналгыг хил хамгаалалтад ашиглах боломжтой;
- Радио холбооны тархац өндөр;
- Хилийн эрлийн ажиллагааг удирдан зохион байгуулахад удирдлагын шийдвэр богино хугацаанд хүрч, бүлгүүдийн маневарлах боломж өндөр байдаг;
- Өвлийн улиралд хилийн зөрчлийг илрүүлэх, саатуулах, хил орчмын дэглэмийг сахиулахад байгалийн бартаа саадыг ашиглан хамгаалах нөхцөл бүрддэг;
- Дорнод, Сүхбаатар аймаг дахь хилийн отрядуудын хариуцсан хэсэгт 388.5 км өргөст утсан хашааг хил хамгаалалтад ашиглаж байна.

Сөрөг тал нь:

- Цасан болон шороон шуургатай үед цэргийн хяналт хийх боломж хязгаарлагдмал болдог ба мал уруудах, хилийн манаа осгох, төөрөх зэрэг эрсдэл гардаг.
- Дэд бүтэц, зам харгуй сул хөгжсөн, төв суурин газраас хэт алслагдмал;
- Хэрлэн, Халх голын сав газрыг эс тооцвол усан хангамж муу, худаг ус ховор, унданд хэрэглэхэд тохиромжгүй, хатуулгийн түвшин нь

зөвшөөрсөн хэмжээнээс их байдгаас бие бүрэлдэхүүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг;

- Хил зөрчигч явж болзошгүй чиглэлийг тогтооход хүндрэлтэй; /Хариуцсан хэсгийн аль ч хэсгээр хилийн зөрчил гарч болзошгүй/

- Газар орны зүйлсээр тэмдэгт авч баримжаалах, солиболцлыг тодорхойлоход бэрхшээлтэй.

- Улсын хил хамгаалалтын арга тактик болон хүч хэрэгслийг шилжүүлэн маневрлах, байрлуулах, хилийн инженер, техникийн төхөөрөмжлөл хийхэд өнгөлөн далдлалтыг зохион байгуулах боломж муу.

- Ой, хээрийн түймэр гарах, байгалийн гамшиг тохиолдох нь элбэг бөгөөд энэ нь улсын хил хамгаалалтад хүндрэл учруулдаг.

Бусад хүчин зүйлүүд:

- Улсын хил зөрчигчдийн үйл ажиллагаа зохион байгуулалттай хэлбэрт шилжиж, орчин үеийн өндөр хүчин чадалтай автомашин, холбоо дохиоллын хэрэгслэл хэрэглэх болсон.

- Хилийн бүс зурвас, хил орчмын нутаг дэвсгэрт улс орны болон бүс нутгийн хөгжилд чухал үүрэг роль бүхий уул уурхай, ашигт малтмалын орд газруудын хайгуул, олзворлолт бий болж тэдгээрийг дагасан олон төрөл үйлчилгээ бий болж, цаашид өргөжих, үүнийг дагалдан хууль бусаар эрдэс баялаг олборлогсдын эгнээ жилээс жилд тэлэн өргөжсөн.

- Тал хээрийн бүсийн хариуцсан хэсэгт БНХАУ-ын Петро чайна, Дайчин тамсаг компани, Хөвсгөл геологи, ХХК хайгуул судалгааны анги, Билүүт, Баянцогт, Нүхтийн нүүрсний уурхайнууд, Шан-Лун зэрэг уул

уурхайн компанийн ажилчид хилийн бүс, зурваст ажил үйлдвэрлэл явуулж байгаагаас шалтгаалж, замбараагүй авто машины мөр гаргах, олон тооны гадаадын иргэд ажиллах зэргээр хил орчмын дэглэм зөрчиж улсын хил хамгаалалтад хүндрэл учруулдаг.

- Сүхбаатар аймгийн өмнөд хилийн хэсгээр байгаль экологийн өөрчлөлт, элсний нүүдэл, цөлжилтийн процесс тасралтгүй явагдаж, үүний улмаас хил хамгаалалтыг зохион байгуулан явуулахад хүндрэл, бэрхшээлт байдлуудыг бий болгож байна.

Монголын Улсын ирээдүйн хөгжлийн төлөвөөр зүүн бүс нутаг нь хэвтээ тэнхлэгийн авто болон төмөр замын гол зангилаа, эдийн засгийн чөлөөт бүс, аялал жуулчлал, газар тариалангийн томоохон бүс нутаг болох хандлагатай.

Тал хээрийн бүсийн улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдахад эерэг, сөрөг талуудад тохирсон хамгаалалтын бодомж, хувилбар боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Өнгөлөн далдлалтын арга хэмжээг сайтар зохион байгуулсан хянах цамхагуудыг байрлуулж, орчин үеийн өндөр хүчин чадалтай теле хяналтын камер, дохиолол хамгаалалтын /зөөврийн/ төхөөрөмж, өдөр шөнийн дуран харааны хэрэгслээр тоноглон хамгаалалтад ашиглах;

- Өвлийн улиралд цас их унадаг хэсгүүдэд орчин үеийн цасны моторт чарга, цаныг өргөн ашиглах;

- Цэргийн хяналтад өртөдөггүй хэсгүүдэд инженерийн торон саадыг байгуулах.

- Хүрэхэд хүндрэлтэй чиглэлүүдэд нисгэгчгүй нисэх хэрэгслийг өргөнөөр ашиглан, хил зөрчигч явж болзошгүй газар оронд үзлэг хийх.

- Хилийн заставыг сансрын холбооны сүлжээнд холбож, хилийн бүс зурвасыг бүрэн хамарсан хэт богино долгионы радио сүлжээ байгуулах.

- Газар орны онцлогыг харгалзан өндөр хүчин чадлын суурин, өдөр шөнийн нөхцөлд ажиллах дуран харааны хяналтын хэрэгслээр хангах.

- Байгаль цаг уурын онцлог нөхцөлд алслагдсан болон цагийн байдлын өрнөлттэй хилийн хэсэгт харуулын алба зохион байгуулах боломжтой тусгай тоноглол бүхий автомашиныг хөдөлгөөнт харуул байдлаар ашиглах.

- Орон нутгийн засаг захиргаа, ард иргэд, хил хамгаалалтад туслах хүчний гишүүд, цэргийн албыг дүйцүүлэн хаагчдыг хил хамгаалалтад өргөнөөр ашиглах.

Дүгнэлт

Тал хээрийн бүсийн хил хамгаалалтын арга тактикийг боловсронгуй болгосноор:

-Хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал хангагдана.

-Улсын хил хамгаалалтын найдвартай байдал, тасралтгүй ажиллагаа хангагдана.

- Хилийн зөрчлийг илрүүлэх боломж эрс дээшилнэ.

- Хамгаалах хэсгийн хяналтанд хамрагдах хэсгийг нэмэгдүүлж, бага хүчээр их хэсгийг хамгаална.

- Теле хяналтын хэрэгслийг хил хамгаалалтад нэвтрүүлнэ.

-Хил хамгаалалтанд орон нутгийн Засаг захиргаа, иргэд хил хамгаалах туслах хүчний гишүүдийг өргөнөөр оролцуулснаар улсын хил хамгаалалтын үр дүн дээшилнэ.

Ашигласан материал:

1. Бүсчилсэн хил хамгаалалт төсөл. Судалгааны ажил, УБ., 2009.
2. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, УБ., 2001.
3. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. УБ., 2002.
4. Наранжамц.Н “Бүс нутаг - хил хамгаалалтын үзэл баримтлал”, УБ. 2012 он.
5. Наранжамц.Н “Тал хээрийн нөхцөлд хилийн операци зохион байгуулж явуулах нь”, диссертац УБ., 2008 он
- 6.Нямдорж.Д “Улсын хилийг инженер, техникийн хэрэгслээр хамгаалах аргыг боловсронгуй болгох нь”, диссертац. УБ., 2005.